БАТЛАВ
"ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ" ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ
Д.ОЮУНБОЛД

# "ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛД МАГАДЛАЛ ХИЙХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦАХИМ СИСТЕМ"-ИЙН НЭМЭЛТ ХӨГЖҮҮЛЭЛТ АЖЛЫН ДААЛГАВАР

2026 оны 01 сарын 16-ны өдөр　　№ 2026/02.　　Улаанбаатар хот

| | |
|---|---|
| 1. **Төсөл боловсруулах үндэслэл:** | • Авто замын норм нормативын сангийн хөрөнгөөр 2025-2026 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөгөө<br>• Систем ашиглах явцад үүсэж буй доголдлуудыг засварлах, систем ашиглагч нарт илүү хялбар бөгөөд ойлгомжтой байдлаар хөгжүүлэлтийг хийж сайжруулах; |
| 2. **Төслийг хэрэгжүүлэхэд ашиглах, дагаж мөрдөх хууль тогтоомж, дүрэм, журмууд:** | • Авто замын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалт, 11 дүгээр зүйлийн 11.1.6 дах заалт,<br>• Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журам |
| 3. **Төсөл хэрэгжих байгууллага:** | • Тухайн чиглэлээр мэргэшсэн зөвлөх баг болон хуулийн этгээд /сонгон шалгаруулалтаар/ байна. |
| 4. **Төслийн бүрдэл:** | • Зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийх үйл ажиллагааны цахим системд нэмэлт хөгжүүлэлт хийх ажлын үе шатны тайлан /Эхлэл, дунд, эцсийн/ |
| 5. **Төсөл хэрэгжүүлэх үе шат:** | • 8 сар /Гэрээ байгуулагдсан өдрөөс хойш/ |
| 6. **Төслийн хүрээнд гүйцэтгэх ажил:** | Сайжруулалт хийгдэх функцууд<br>• Зам тээврийн яамны нэгдсэн мэдээллийн санд илгээж байгаа мэдээллийг илүү нарийн нууцлал, хамгаалалттай болгох<br>• Экспертийн бүртгэлийг нарийвчлан бүртгэх<br>• Зураг төслийн явцын алхмыг шинэчлэн, ойлгомжтой байдлаар бүртгэх<br>Шинээр хийгдэх функцууд<br>• Notification system: Захиалагч хэрэглэгчдэд и-мэйл, мессежээр баталгаажилт, мэдэгдэл өгөх зорилготой.<br>• Help: Тусламж цэс нь хэрэглэгчдэд ерөнхий болон нарийвчилсан заавар зөвлөмжийг харуулна. |

- Файлын сан: 2015 оноос хойших файлыг сервер дээр файлын сан хэлбэрээр зохион байгуулалт хийнэ.
- Баталгаажуулалт, танилт нэвтрэлт: захиалагч, экспертүүдийг ДАН танилтын системээр баталгаажуулах
- AI функц нэмэх: хайлт, дүгнэлт, ерөнхий мэдээллийг агуулсан мэдээллээр харилцан ойлголцдог болох
- Text editor: Шаардлагатай текст мэдээллийг засах энгийн функц нэмэх
- Магадлалын системийн хайлт хэсгийг боловсронгуй болгох, түлхүүр үгээр хайхад тухайн мэдээлэл бүрэн эхээр харагддаг эсвэл файл байгаа хэсгийг зааж өгдөг байхаар сайжруулах;
- Зураг төслийн байгууллага нь магадлалын ажлын төлбөрийг төлөөгүй, магадлагдсан зураг төслийг файл хэлбэрээр ирүүлээгүй тохиолдолд томилгооны хүсэлт явуулахад анхааруулга өгдөг цаашлаад томилгооны хүсэлт явуулах боломжгүй байхаар нэмэлт сайжруулалт хийх;
- Эксперт өвчтэй, тодорхой хугацаагаар ажиллах боломжгүй үедээ системд мэдэгдлээ оруулдаг байх уг мэдээлэл нь төвийг холбогдох мэргэжилтнүүдэд харагддаг байхаар хөгжүүлэлт хийх;
- Магадлалын системд нэвтрэх, орох хэсэгт магадлалын үйл ажиллагаа нь аль явц дээр байгааг нарийвчлан харагдах байдлыг сайжруулах;

**7. Төслийн эцсийн үр дүн:**

- Зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийх үйл ажиллагааны цахим системд нэмэлт хөгжүүлэлт, сайжруулалтыг гүйцэтгэсэн байна

**8. Төслийг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр, хэмжээ:**

- Авто замын норм нормативын сан
- 20.0 сая төгрөг

**9. Гүйцэтгэх багт тавигдах шаардлага:**

- Программ хангамж хөгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.
- Программ хангамжийн мэргэжлийн 3-аас доошгүй ажилтантай байх
- UI/UX мэргэжлийн дизайнер ажилтантай
- Цахим системийн хөгжүүлэлт, боловсруулалтыг гүйцэтгэж үйлчилгээ эрхэлж байсан туршлагатай байх

**10. Төслийн онцгой нөхцөл:**

- Авто замын тухай хууль болон бусад хууль дүрэм журам, цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой дүрэм журамд нийцүүлэн боловсруулалтыг гүйцэтгэх
- Программыг хэрэглэгч талуудын дунд (хэлтсийн холбогдох мэргэжилтэн, экспертүүд, зураг төслийн байгууллага) систем хөгжүүлэлт,

ашиглалттай холбоотойгоор сургалт зохион байгуулах;

- Системийн дата өгөгдлийн бүрэн бүтэн байдлыг дангаар хариуцна.
- Программ хангамжийн хэвийн үйл ажиллагааны баталгаат хугацаа 3 сараас доошгүй байна.
- Шинэ хөгжүүлэлтийн нэвтрүүлэлт, аюулгүй ажиллагааг бүрэн хариуцна.
- Төслийн хүрээнд цуглуулсан мэдээлэл, судалгааны үр дүн, программ хангамж, түүний эх код нь "Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай" хуулийн 17.2 дах заалт, 8 дугаар зүйлийн дагуу Захиалагч "Зам тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-ын өмч болно.

**ХЯНАСАН:**

Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт норм нормативын хэлтсийн дарга — Э.БАЛТ

**БОЛОВСРУУЛСАН:**

Бодлогын хэрэгжилт, зураг төслийн магадлал, стандарт норм нормативын хэлтсийн мэргэжилтэн — Э.ЭНХТӨГС